

МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны жилийн эцэс

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Улсын Их Хурлын 2020 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д Эрчим хүчний яамны хариуцан хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээний 2023 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилт, үр дүнг үнэлж, үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт, хариуцлагыг сайжруулахад оршино.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үндэслэл, арга зүй

Таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан Эрчим хүчний яамны хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээнүүдийн 2023 оны жилийн эцсийн байдлаарх хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлыг гүйцэтгэхдээ Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн хэрэгжилт, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт, Монгол Улсын хөгжлийн 2023 оны төлөвлөгөөний биелэлт, салбарт гадаадын зээл тусламжаар хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааны тайланг судлах, тухайн ажлыг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж ярилцах, холбогдох газруудаас тодруулга авах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн гүйцэтгэв.

Төлөвлөсөн арга хэмжээ бүрийн 2023 онд хэрэгжүүлсэн ажлын хүрсэн түвшин, үр дүнг шалгуур үзүүлэлт болон хүрэх түвшинтэй харьцуулан тус бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн явцыг гаргав.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Монгол Улсын 2021-2025 оны таван жилийн үндсэн чиглэлд эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан 7 арга хэмжээ 2023 оны жилийн эцсийн байдлаар **59** хувийн хэрэгжилттэй байна.

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин/ Хэрэгжилт %
			он	хүрэх түвшин	
Зорилт 4.2. Эдийн засгийн бүтцийн шинэчлэлийг эхлүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэн, экспортод чиглэсэн хүнд, хөнгөн үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.					
1	4.2.7.эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг хөгжүүлнэ.	Төслийн гүйцэтгэлээр	2024	100%	53,73%
2	4.2.8.цахилгаан станцуудыг өргөтгөж, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийг барьж, цахилгаан эрчим хүчээр дотоодын хэрэгцээг бүрэн хангана.	Шинээр нэмэгдэх суурилагдсан хүчин чадлын өсөлтөөр	2025	Суурилагдсан чадал 815 МВт-аар нэмэгдэнэ.	40,8%
3	4.2.11.эрдэс баялгийн экспортын зонхилох хувийг эзэлж байгаа нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр, түүхий нефть зэргийг нэмүү өртөг, үнэ цэнэ шингээн боловсруулж,	Төслийн гүйцэтгэлээр	2025	2026 онд суурилагдсан чадал 450 МВт,	50%

	экспортлох хүрээнд нүүрс-химийн, зэсийн баяжмалын, төмөрлөгийн зэрэг хүнд үйлдвэрийн бүтээн байгуулалтыг нэн яаралтай эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох төмөр зам, ус, эрчим хүчний төслүүдийг хэрэгжүүлнэ.			2025 онд 230 км ЦДАШ нэмэгдэнэ.	
4	4.2.12.улс, орон нутгийн төсөвт ачаалал үүсгэхгүй төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлбэрээр орон нутгийн хот, суурин газарт цахилгаан, дулааны эх үүсвэрийг нэмэгдүүлнэ.	Шинээр нэмэгдэх суурилагдсан хүчин чадлын өсөлтөөр	2025	Суурилагдсан чадал 400 МВт-аар нэмэгдэнэ.	30%
5	4.2.13.Баянтээг нүүрсний уурхайг түшиглэн 20 МВт-ын цахилгаан станц барьж, сайжруулсан шахмал түлшний үйлдвэрийг өргөтгөн, хөрш зэргэлдээх аймгуудын түлшний хэрэгцээг хангаж, агаарын бохирдлыг бууруулна.	Төслийн гүйцэтгэлээр	2025	Сайжруулсан шахмал түлшний үйлдвэр баригдсан байна.	50%
6	4.2.14.Завхан, Говь-Алтай аймгуудын эрчим хүчний дутагдлыг арилгах зорилгоор шаардлагатай агаарын шугам, дэд станц, шинэ эх үүсвэрийн шинэчлэл, барилгын ажлыг хэрэгжүүлнэ.	Төслийн гүйцэтгэлээр	2024	Төслийн хэрэгжилт 100%	99%
7	4.2.16.эрчим хүчний дотоодын хэрэгцээг бүрэн хангасан, тогтвортой, өөрийгөө зохицуулах чадвар бүхий системийг бүрдүүлнэ.	Төслийн гүйцэтгэлээр	2024	100%	90%
Хэрэгжилтийн дундаж хувь					59,0%

**“МОНГОЛ УЛСЫГ 2021-2025 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ”-ИЙН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ХҮРЭХ ТҮВШНИЙ БИЕЛЭЛТ**

2023 оны жилийн эцэс

№	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Суурь түвшин	Хүрэх түвшин (2025 он)	Хүрсэн түвшин (2023 он)	Мэдээлэл цуглуулах давтамж	Хариуцах байгууллага
1	Цахилгаан эрчим хүчээр хангагдсан хүн амын эзлэх хувь	хувь	-	95.5	99.3	Жилд нэг удаа	Эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага

2023 оны жилийн эцсийн байдлаар улсын хэмжээнд нийт 933 928 өрх байгаагаас 926 888 буюу 99.3 хувь нь цахилгаан эрчим хүчний эх үүсвэрт холбогдсон. Үүнээс эрчим хүчний нэгдсэн системээс 81,2 хувь, сэргээгдэх эрчим хүчний эс үүсвэрээс 16.4 хувь, дизель станцын эх үүсвэрээр 0.1 хувь, өөрийн бага оврын эх үүсвэрээс 1.5 хувь нь тус тус хангагдаж байна.

Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж

- Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд эрчим хүчний салбарын чиглэлээр тусгагдсан 7 арга хэмжээний хэрэгжилтийн явц 2023 оны жилийн эцсийн байдлаар 59 хувьтай байна.
- Бараа материалын үнэ, валютын ханшийн өсөлт зэрэг хүндрэлтэй нөхцөл байдлын үед барилга, угсралтын ажил гүйцэтгэж байгаа гүйцэтгэгч компаниудад үүсэж буй хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх, барилга угсралтын ажлыг эрсдэл багатай, хурдан шуурхай гүйцэтгэх нөхцөл бололцоогоор хангах асуудлыг тухай бүр шуурхай шийдвэрлэн захиалагч Эрчим хүчний яамны зүгээс удирдлага, зохион байгуулалтын

арга хэмжээг авч ажилласны үр дүнд гадаадын зээл, тусламжаар хэрэгжиж төслүүд, мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдэд тодорхой ахиц, үр дүн гарсан байна.

- Удаашралтай байгаа болон барилга угсралтын ажлын түвшинд байгаа төслүүдийн хэрэгжилтийг эрчимжүүлж, жилийн эцэст шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинд хүргэх шаардлагатай байна.
- Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл нь түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төсөв, санхүүгийн тооцоо, эх үүсвэртэй нь уялдуулан төлөвлөсөн баримт бичиг болох Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр болон үндсэн чиглэлд тусгагдсан зорилго, зорилтыг тухайн жилд хэрэгжүүлэх төсөв, санхүүгийн эх үүсвэрийг тусгасан төсөл, арга хэмжээ бүхий төлөвлөлтийн баримт бичиг болох Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөгөөр дамжин хэрэгжих тул уг 2 бодлогын хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай.

Арга хэмжээний дэлгэрэнгүй биелэлтийг хавсаргав.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр